

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮҮХЭН ХАНДЛАГА

Б. Нарантулга (Ph.D), Удирдлагын академийн Улс төр судлал,
нийгмийн удирдлагын тэнхмийн ахлах багш

Хураангуй

Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түүхэн хандлагыг улс орны нийгэм эдийн засгийн байдал, төрийн бодлоготой уялдуулан судлахад *нэгдүгээрт*, их бүтээн байгуулалт буюу аж үйлдвэржилтийн нөлөөгөөр Улаанбаатар хотыг зорьсон; *хоёрдугаарт*, газар тариаланг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаатай холбоотой сангийн аж ахуй байгуулагдсан аймгууд руу чиглэсэн; *гуравдугаарт*, аж үйлдвэрийн шинэ төв Дархан, Эрдэнэт хот руу чиглэсэн; дөрөвдүгээрт, амьжиргааны боломж, арга зам эрэлхийлэн Улаанбаатар хот руу тэмүүлсэн гэсэн дөрвөн их нүүдэлд ангилж болохоор байна.

Түлхүүр үг: Шилжих хөдөлгөөн, шилжих хөдөлгөөний урсгал, нийгэм эдийн засгийн байдал, татах хүчин зүйл, төрийн бодлого, хөдөлмөрийн нөөцийн хангамж, амьжиргаагаа дээшлүүлэх арга зам

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд ардын хувьсгалаас хойш нэгэн шинэ эрин үе эхэлснээр ард түмний аж амьдралд эрс өөрчлөлт гарсан билээ. Түүнчлэн өнөөдрөөс зуу орчим жилийн тэртээ 1918 онд анхны хүн амын тооллого явагдсанаар хүн ам зүйн үзэгдэл, үйл явцыг тайлбарлах, дүн шинжилгээ хийхэд бодитой баримт сэлт бүрдсэн гэж үздэг. Иймээс Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг 1921 оноос эхлэн судлах нь нэг талаас мэдээллийн бичмэл эх сурвалжид тулгуурлах, нөгөө талаас хотжих, суурин иргэншилд шилжих үйл явц эрчимтэй эхэлсэнтэй давхцаж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Үндэсний орлогынхоо 90 гаруй хувийг¹ дан ганц мал аж ахуйгаас, үлдэх багахан хэсгийг ан агнуур, байгалийн баялаг олзвороос бүрдүүлж, үүнтэй холбоотойгоор нийт иргэдийн 80 гаруй хувь нь² нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөдөө орон нутаг амьдарч байсан хандлага ардын хувьсгалын дараагаар өөрчлөгдөв. 1921 оны ардын хувьсгалын ялалт нь төрийн бодлого, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад дараах хувьслыг бий болгожээ³. Үүнд:

Эдийн засгийн салбарт хямарч доройтсон аж ахуй, эдийн засгийг өөд татан эмхлэх, гадаадын худалдаа, мөнгө хүүлэгчдийн өр, зээлээс ард олныг ангижруулах, алба татварыг эмх цэгцтэй болгох, үндэсний худалдааг үүсгэн хөгжүүлэх, дотоод гадаад худалдаанд төрийн хяналтыг тогтоох, банк зээлийн байгууллагыг үүсгэн үндэсний мөнгөн тэмдэгт гаргах, ард олонд аж ахуйгаа эрхлэн явуулахад нь төрийн тусламж, дэмжлэг үзүүлэх бололцоо бүрдэв.

- Улс төрийн талаар Монгол орныг цагаантны үлдэгдлээс бүрэн чөлөөлөх, орон нутагт ардчилсан засаг захиргааг байгуулах, ард иргэдийн тэгш эрхийг хангах, гадаадын харъяат иргэдийн эх нутагт нь буцаах, ноёд язгууртны хэргэм зэргийг хязгаарлах, ард олныг албат хамжлагын байдлаас чөлөөлөх үйл явц эхэлжээ.
- Соёлын салбарт орчин үеийн иргэний сургууль, соёл, урлагийн байгууллагуудыг үүсгэн хөгжүүлэх, шашны мухар сүсгийн нөлөөг хязгаарлан шинжлэх ухааны мэдлэг, ухааныг дэлгэрүүлэх, хүн ардаа үндэснийхээ бичиг үсгийг сургах замаар ардын боловсрол, соёл урлаг,

¹ Ж. Заанхүү, Т. Алтанцэцэг, Монголын түүхийн лекцүүд, Цагдаагийн дээд сургууль, УБ., 1999, 327 дахь тал

² Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000, НХХЯ, ХАССТ, НУБХАС, УБ., 2001, 3 дахь тал

³ С. Идшинноров, Улаанбаатар хотын түүхийн хураангуй, УБ., 1994, 63-64 дэх тал

шинжлэх ухааны салбарт гүнзгий өөрчлөлт хийх ажлын суурийг тавьсан.

Эдгээр арга хэмжээний үр дүнд 1930-аад он гэхэд Монгол Улсад тээвэр, холбоо, эрчим хүч, барилга, дотоод, гадаад худалдаа, банк, санхүү, сургууль, эмнэлэг зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд хөгжих эхлэл үндсэндээ тавигдсан байжээ. Тухайлбал, 1921 онд анхны бага сургууль; 1923 онд 60 квт-ын хүчин чадалтай анхны дизель станц; 1924 онд Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк; 1925 онд 12 машинтай анхны улсын тээх, нэвтрүүлэх хороо; 1925 онд хивсний үйлдвэр; 1932 онд аж үйлдвэрийн комбинат байгуулагдаж, ашиглалтанд орж байсан түүхтэй. Дээр дурьдсан үйлдвэржилт, бүтээн байгуулалтын ажил бүхэлдээ нийслэл

Улаанбаатар хотод төвлөрч байсан нь тус хотыг засаг захиргаа, худалдаа үйлдвэрлэл, боловсрол, соёл, шинжлэх ухааны хамгийн гол төв болгож, улмаар шилжигчдийг татах үйл явцын эхлэх гол нөхцлийг бүрдүүлсэн юм. Чухамхүү эл нөхцөл байдлын улмаас манай улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд хөдөөгөөс хот руу, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн 'их нүүдэл' гэхээр үйл явц өрнөж эхэлсэн билээ.

1924 оны 3-р сард “Монгол улсын хотын захиргааны дүрэм”-ийг баталж, хотын жинхэнэ захиргаа байгуулах, үүний тулд хотын жинхэнэ харъяат иргэдийг тоолж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын нийт оршин суугчдын тоог гаргахад 57 хувь нь Монгол улсын харъяат иргэд, 43 хувь гадаадын харъяат иргэд байжээ.

Хүснэгт 1: Нийслэл хотын хүн амын бүтэц, тоо хэмжээ, 1925 оны байдлаар

Хүн амын бүтэц	Тоо	Хувь
Энгийн ба албан ажлын Монгол иргэд	14750	24.1
Гандан хүрээнээ шавилан суух данстай лам нар	20000	32.7
Хятад улсын харъяат иргэд	23919	39.2
Зөвлөлтийн харъяат Орос ба бусад үндэстэн	1773	2.9
Хятад, ЗХУ-аас бусад гадаадын 19 улсын иргэд	644	1.1
Нийт	61086	100.0

Эх сурвалж: Л. Дүгэрсүрэн, Улаанбаатар хот 1921-1940, УБ., 1963, 68 дахь тал

Хүснэгтээс харахад 1925 онд нийслэлд оршин суугаа Монгол иргэдийн тоо лам нарыг оролцуулаад 34750 байсан бол 1940 онд зөвхөн аж үйлдвэрийн салбарт ажиллах Монголчуудын тоо 14000 болсон гэх мэдээ байна⁴. Цаашилбал, 1922 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ нэг бум төгрөг байсан бол 1932 онд 3 сая, 5 бум, 1940 онд 77 сая төгрөгт⁵ хүрч огцом өсөлт ажиглагдсан нь Монгол улсын эдийн засгийн салбаруудын эрчимтэй өсөлтийг харуулах жишээ баримт мөн.

Аж үйлдвэр, дэд бүтэц, үйлчилгээний салбар хөгжихтэй зэрэгцэн өсөн нэмэгдэж буй ажиллах хүчний хэрэгцээг хангахын тулд хөдөө орон нутгаас иргэдийг зохион байгуулалттайгаар шилжүүлэн суурьшуулах

ажил 1930-аад оноос эхэлж⁶, 1960-аад оноос улам идэвхижсэн байна. Жишээ татвал, 1960-1970 онд техник мэргэжлийн сургуулиас үйлдвэрт 42 мянган охид, хөвгүүд⁷ шууд шилжин ажилласан нь бүтээн байгуулалтын үед ажиллах хүчний хэрэгцээг хангах зорилготой төрийн бодлогын нэг хэсэг байсан юм.

Ийнхүү зохион байгуулалттай шилжих хөдөлгөөний зэрэгцээ хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ажиллах, суралцах, зорилгоор сайн дураараа шилжин суурьших хөдөлгөөн хорьдугаар зууны хориод оноос эхэлсэн. Жишээ нь 1928 оны байдлаар Улаанбаатар хотын жинхэнэ оршин суугч болох өргөдлөө гаргасан 87⁸ өрх айл байсан талаар тэмдэглэсэн нь бий.

4 С. Идшинноров, Улаанбаатар хотын түүхийн хураангуй, УБ., 1994, 108-109 дэх тал

5 Т. Намжсүм, Монгол улсын эдийн засаг: Эрт, эдүгээ, чинагш, Боть 1, МУ-ын шинжлэх ухааны академи, УБ., 2004, 308 дахь тал

6 Мөн тэнд, 128 дахь тал

7 Ч. Жамбал, Орчин цагийн Улаанбаатар, 1984, 29 дэх тал

8 С. Идшинноров, Улаанбаатар хотын түүхийн хураангуй, УБ., 1994, 86 дахь тал

1960-аад оноос Улаанбаатар хотын амьдралын түвшин, аж төрөх нөхцөл, эмнэлгийн болон бусад үйлчилгээ, соёл, сургууль, соёл гээд бүхий л талаараа хавьгүй илүү байсан тул хөдөө амьдрагчид хотын суурьшмал хэв маягт татагдах

нь ихсэв. Энэхүү хүн амын механик хөдөлгөөний дүнд 1935 оны тооллогоор 10385 хүн амтай хэмээн бүртгэгдэж байсан Улаанбаатар хотын хүн ам 30 орчим жилийн дотор 21.5 дахин нэмэгдэж, 1963 оны тооллогоор 223 мянгад хүрчээ.

Хүснэгт 2: Улаанбаатар хотын хүн амын тоо, 1935-1963 оны тооллогоор


Он	Улаанбаатар хотын хүн амын тоо	МУ-ын нийт хүн амын тоо	Нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь
1935	10385	738200	1.4
1944	30362	759061	4.0
1956	118387	845481	14.0
1963	223695	1017158	22.0

Эх сурвалж: Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, ҮСХ, УБ., 2003, 80-81 дэх тал

Цаашилбал энэ хугацаанд Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт улсын түвшнээс 4-өөс илүү дахин, зарим үед 26 дахин нэмэгдсэн байна.

1935-1944 онд манай улсын нийт хүн ам жилд дунджаар 0.3 хувийн өсөлттэй байхад Улаанбаатар хотын хүн ам 21.4 хувийн өсөлттэй байсан ажээ.

Зураг 1: 1935-1963 оны тооллого хоорондын хүн амын жилийн дундаж өсөлт



Эх сурвалж: Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, ҮСГ, УБ., 2003, 382-383 дахь талд суурилсан судлаачийн нэгтгэл

Ийнхүү Улаанбаатар хотын хүн амын тоо шилжих хөдөлгөөний улмаас нэмэгдэж, 1963 оны байдлаар МУ-ын нийт хүн амын 22 хувь нь зөвхөн нийслэлд төвлөрсөн. Үүнээс манай улсын засаг захиргааны нэгжүүдэд хүн ам ойролцоо хэмжээтэйгээр суурьших ёстой гэж үзвэл хүн амын төвлөрлийн хандлага тэртээ 1950-аад оноос эхэлсэн гэж дүгнэж болохоор байна.

Нэмж тэмдэглэхэд, бүтээн байгуулалттай зэрэгцэн явагдсан нэгдэлжүүлэх хөдөлгөөний дүнд шинээр байгуулагдсан олон нэгдлийг томруулж, малыг таван хошуу, нас, хүйсээр

нь ялган суурь зохион байгуулалтад оруулсанаар хөдөөд бий болсон илүүдэл ажиллах хүчин мөн л хөдөлмөр шингээх чадвар бүхий нийслэлд шилжин суурьшиж байлаа.

Шилжих хөдөлгөөний Улаанбаатар хотыг зорьсон энэхүү их нүүдлийг доктор Х. Гүндсамбуу шилжих хөдөлгөөний анхны томоохон давалгаа хэмээн тэмдэглэсэн нь бий. Хотын их бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөгжил хөдөөгийн оршин суугчдыг соронздон татаж, гучаадхан жилийн дотор хүн амын тоог 20 дахин

нэмэгдүүлж чадсан учраас түүхэнд шилжих хөдөлгөөний анхны давалгаа хэмээсэн нь зохисон тодотгол гэлтэй.

Хөдөөгөөс хот руу чиглэсэн энэхүү томоохон давалгаатай зэрэгцэн хотоос хөдөөд чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал бас байсныг тэмдэглэхгүй орхиж болохгүй юм. Ардын хувьсгалын дараагаар соёлын салбарт хийгдсэн шарын шашны нөлөөг хязгаарлах бодлогын дүнд лам нарын ихэнх нь хүрээ хийдээс ангижран үйлдвэр, аж ахуйн газарт ажиллах болсон бол нэг хэсэг нь хөдөө гарч, мал аж ахуй эрхлэх болсоноор хотоос хөдөөд чиглэсэн шилжих хөдөлгөөний багахан хэмжээний урсгалыг бий болгосон байна.

Нийслэл Улаанбаатар хотыг зорьсон шилжих хөдөлгөөний үр дүн шилжигчдэд эергээр нөлөөлсөн талаар зарим эх сурвалжид тэмдэглэгджээ. Жишээ нь, Улаанбаатар хотноо үүсэж байгуулагдсан албан газар, улсын үйлдвэр, үйлчилгээний газрууд нь хотын оршин суугчдаас ажиллах хүчээ үнэлж, аж амьдралаа өөд татахад нь чухал нөлөө үзүүлж байв⁹ гэсэн баримт бий. Энэ нь ажлын байр бүхий шилжих хөдөлгөөний улмаас иргэд тогтмол орлоготой болж, улмаар амьдрал, ахуйгаа дээшлүүлэх үндэс бүрдэж байсныг харуулж байна.

Нөгөөтэйгүүр, эдийн засгийн өсөлт нь хөдөлмөрчдийн цалингийн түвшин өсөхөд таатай нөлөө үзүүлж байжээ. 1960 оныг 1980 онтой харьцуулахад улс ардын аж ахуйд ажиллагчдын цалингийн хэмжээ 1.3 дахин, аж үйлдвэрт ажиллагчдынх 1.6 дахин, ХАА-д ажиллагчдынх 1.7 дахин тус тус нэмэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор хөдөлмөрчдийн эрэлт, хэрэгцээ тасралтгүй өсөн нэмэгдэж, худалдан авах чадвар сайжирч, 1960 онтой харьцуулахад 1980 онд автомашины худалдан авалт 5.1 дахин, мотоциклийн худалдан авалт 7.7 дахин, мөнгөн хадгаламж 40 дахин тус тус нэмэгдсэн¹⁰. Ийнхүү удаан эдэлгээт бараа,

бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, хуримтлал бий болж байгаа нь хүн ам, тэр дундаа шилжин суурьшигч өрх, хүн амын орлогын хүрэлцээт байдал, амьжиргааны харьцангуй боломжийн түвшинг илтгэж байна.

1921 онд Хараагийн тариалангийн сан байгуулах, 1924 онд “Монголчуудын тариалангийн дүрэм”-ийг боловсруулж батлах, 1948-1952 оны анхдугаар таван жилийн төлөвлөгөөнд газар тариаланг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэх байдлаар эхэлсэн газар тариаланг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд 1958 оны 3 дугаар сард хуралдсан МАХН-ын 8 дугаар их хурлын шийдвэр онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг¹¹. Уг хурлын шийдвэрээр 1959 онд Сэлэнгэ, Хөвсгөл, Дорнод, Төв аймагт дөрвөн сангийн аж ахуй байгуулсанаар шилжих хөдөлгөөний хөдөөг зорьсон их нүүдэл эхэлсэн билээ. Атар газар эзэмших, газар тариалан эрхлэхтэй холбоотой шилжих хөдөлгөөн 1970-аад оны төгсгөл хүртэл үргэлжилсэн.

Хүснэгт 3-д дурьдсан мэдээлэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотоос гадна САА байгуулагдсан аймгуудад шилжих хөдөлгөөний нөлөөгөөр хүн амын тоо нэмэгдсэнийг харуулж байна. Тухайлбал, 1956-1963 оны тооллогын мэдээгээр 18 аймгаас зөвхөн Сэлэнгэ аймгийн хүн ам шилжих хөдөлгөөний улмаас 3.8 мянгаар нэмэгдсэн, 1963-1969 онд Сэлэнгэ, Дорнод, Төв, Хөвсгөл зэрэг анхны САА байгуулагдсан аймгуудад хүн ам шилжих хөдөлгөөний нөлөөгөөр нийтдээ 5 мянгаар нэмэгдсэн байв. Харин бусад аймгуудын хүн ам 8.9 хүртэл мянгаар буурсан байлаа. Шилжих хөдөлгөөний энэхүү урсгал, чиглэлийг Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд тохиосон хоёр дахь ‘их нүүдэл’ хэмээн үзэж болохоор байна.

Өөрөөр хэлбэл, Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өөр чиглэлийн нэгэн шинэ урсгал нь хотоос газар тариалан эрхлэх боломжтой аймгууд руу чиглэсэн шилжих хөдөлгөөн байлаа. Энэхүү шилжих хөдөлгөөний цаана мөн л ажлын

9 С. Идшиноров, Улаанбаатар хотын түүхийн хураангуй, УБ., 1994, 71 дэх тал

10 Д. Мясмар, БНМАУ-ын хүн амын хөдөлмөр эрхлэлт, шилжих хөдөлгөөний асуудал, УБ., 1975 он, 30-31 дэх тал

11 Т. Намжим, Монгол улсын эдийн засаг: Эрт, эдүгээ, чинаги, Боть 1, МУ-ын шинжлэх ухааны академи, УБ., 2004, 467-478 дахь тал

байртай уялдуулан боломжит бүс нутаг руу шилжүүлэн суурьшуулах төрийн бодлого хэрэгжиж, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ өрнөж байсан юм.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний гурав дахь 'их нүүдэл' нь аж үйлдвэр, бүтээн байгуулалтын шинэ хотууд болох Дархан, Эрдэнэт хотууд байгуулагдсантай зүй ёсоор холбогдоно.

Монголын хоёр дахь хот Дарханы суурийг тухайн үеийн Давхрын төмөр замын өртөө, барилгын түүхий эдийн ордуудыг түшиглэн 1961 онд, гуравдахь хот Эрдэнэтийн суурийг байгалийн түүхий эдийн ордуудыг түшиглэн 1973 онд тус тус тавьсанаар хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөний урсгал, чиглэлд өөрчлөлт гарсан нь дээрх хүснэгтээс тодорхой харагдаж байна.

Хүснэгт 3: Хүн амын дотоод цэвэр шилжих хөдөлгөөн, 1956-1979 оны тооллогоор

Аймаг, хот	1956-1963	1963-1969	1969-1979
Архангай	-8.3	-0.9	-18.9
Баян-Өлгий	-2.8	-8.9	-5.9
Баянхонгор	-4.8	-0.2	-6.9
Булган	-3.0	-0.4	-7.8
Говь-Алтай	-6.3	-1.0	-7.4
Дорноговь	-0.6	-0.8	+1.5
Дорнод	-0.6	+0.6	+1.5
Дундговь	-0.8	+0.1	-1.6
Завхан	-6.1	+0.4	-14.6
Өвөрхангай	-3.6	-1.4	-6.6
Өмнөговь	-1.2	-0.1	-1.7
Сүхбаатар	-4.8	-1.6	+4.2
Сэлэнгэ	+3.8	+2.2	+0.8
Төв	-12.7	+1.3	-3.5
Увс	-4.4	-1.0	-0.8
Ховд	-3.6	-1.1	-8.4
Хөвсгөл	-5.1	+0.9	-10.5
Хэнтий	-5.1	-0.5	-0.7
Дархан	+7.0	+6.4	+10.5
Эрдэнэт	-	-	+30.0
Улаанбаатар	+78.0	+15.0	+55.4

Эх сурвалж: Х. Гүндсамбуу, Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага, УА, УБ., 2002, 585 дахь тал (дам ишлэв)

Монгол Улсын хүн амын 1989 оны тооллогоор шинээр байгуулагдсан Дархан, Эрдэнэт хотуудын хүн ам нийлээд 141.8 мянгад хүрсэн нь бага тоо биш юм. Эдгээр хотуудын хүн ам дээрх хугацаанд нийт хүн амын 6.9 хувийг, хотын хүн амын 12.3 хувийг тус тус эзэлж байв. Ийнхүү шилжин ирэгчидтэй холбоотой ачааллыг дан ганц Улаанбаатар хот руу бус, өөр хоёр хот хуваалцах болсон нь хүн амын суурьшил, нийгэм, эдийн засгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой зүйл болжээ.

Нийслэл рүү хөвөрсөн шилжих хөдөлгөөн урсгалаараа явагдсаар тодорхой хугацааны

дараа хөдөө аж ахуйд ажиллах хүчнийг дутагдалд оруулсан учир 1980-аад оны сүүлийн жилүүдэд хөдөөний паспортын чанга дэглэмээр дамжуулан хөдөөнөөс Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг хязгаарлах оролдлого хийж эхэлсэн. Гэвч шилжих хөдөлгөөн нь дан ганц паспортын дэглэмээс хамаардаг, түүгээр зохицуулагддаг зүйл биш учраас шилжих хөдөлгөөн хязгаарлагдаагүй боловч урсгал нь тодорхой хэмжээгээр саарсан байна¹². 1969-1979 оны хооронд 4.2 хувийн жилийн дундаж өсөлттэй байсан Улаанбаатар


¹² Х. Гүндсамбуу, Монголын нийгмийн давхраажил: Хөгжил, хандлага, Удирдлагын академи, УБ., 2002, 518-519 дэх тал

хотын хүн ам 1979-1989 онд 3 хувь болж, 1.2 пунктээр буурсан дүнтэй байв.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн системд шилжсэн 1990-ээд оноос Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түвшин

дахин нэмэгдсэн хандлага ажиглагддаг. 1989 оны тооллогоор манай улсын дөрвөн хүн тутмын нэг нь дотоод шилжих хөдөлгөөнд оролцож, төрсөн нутгаасаа өөр нутаг оронд амьдарч байсан бол энэ тоо 2010 онд 41.5 болж, 20 жилийн дотор 16.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2: Шилжих хөдөлгөөний түвшин, (нийт хүн амд шилжин суурьшигчдын эзлэх хувиар, 1989, 2010 оны тооллогоор)



Эх сурвалж: Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, ҮСГ, УБ., 2003, 382-383 дахь тал; Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Үндсэн үр дүн, ҮСХ, УБ., 2011, 36 дахь талд тус тус суурилсан судлаачийн нэгтгэл

1990-ээд оноос хойш хүн амын шилжих хөдөлгөөний түвшин бүх бүсэд өсөлттэй байсны дээр Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн хувь хамгийн өндөр түвшинд хүрчээ. Өөрөөр хэлбэл, тус хот шилжин ирэгчдийг хүлээн авч буй хамгийн гол бүс нутаг болох нь тодорхой харагдана (Хүснэгт 4).

1990-ээд онд хүн амын цэвэр шилжилтийн түвшин 2-4 оронтой тоогоор тодорхойлогдож байсан бол 2000 оноос 3-5 оронтой тоогоор тодорхойлогдох болжээ. Энэ нь Зураг 2-д үзүүлсэнтэй нэгэн адил Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөн нийт дүнгээр өссөн болохыг харуулах баримт юм.

Дийлэнх аймгуудад шилжин ирсэн хүн амын тоо шилжин явсан хүн амын тооноос доогуур, өөрөөр хэлбэл цэвэр шилжилт сөрөг утгатай хандлага ажиглагдлаа. Энэ нь Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн цөөн хэдэн аймаг, хотод төвлөрөх байдал бий болсныг илтгэнэ. Улаанбаатар хот,

Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгууд авч үзэж буй хугацааны бүх интервалд, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ, зэрэг цөөн хэдэн аймгууд хугацааны зарим интервалд шилжих хөдөлгөөнийг 'хүлээн авагч' нутгууд байсан нь тодорхой. Харин баруун бүсийн аймгуудаас хамгийн олон тооны иргэд төвийн бүсийн аймгууд болон нийслэлийг зорин ирж, шилжин суурьшжээ.

Улаанбаатар хотын хүн амын цэвэр шилжилтийн тоо бусад аймгуудаас хамгийн өндөр, цаашлаад цэвэр шилжилт жилээс жилд өсөж буй хандлагатай байна. Тухайлбал, 1990 онд тус хотод шилжин ирэгч, шилжин явагчдын зөрүү 2.6 мянга байсан бол 2010 онд даруй 15.5 дахин нэмэгдсэн байна. Эндээс шилжих хөдөлгөөнд оролцогчдын зорилтот газар бол Улаанбаатар хот болох нь нэгэнт илэрхий.

2010 оноос шилжин суурьшигчдыг хүлээн авч буй нэг шинэ нутаг нэмэгдсэн нь Өмнөговь аймаг байлаа. Оюу толгой,

Таван толгой зэрэг ашигт малтмалын орд газруудын олборлолт, ашиглалттай холбоотойгоор тус аймгийг чиглэсэн шилжих хөдөлгөөн 2005 оноос хойш эрчимжсэн юм.

Дархан-Уул, Орхон зэрэг аймгуудаас гадагш шилжигчид, дотогш шилжигчдээс бага, өөрөөр хэлбэл цэвэр шилжилт ажиглагдаж байгаа мэт боловч энэ нь 'завсрын нутаг' буюу дамжин өнгөрөх цэг¹³ болж байгаа талаар Хүн ам, орон сууцны

2010 оны улсын тооллогод тулгуурлан хийсэн "Шилжих хөдөлгөөн, суурьшил" сэдэвчилсэн судалгаанд дурьджээ.

Энэ нь Улаанбаатарт шилжин суурьших хүсэлтэй өрх, иргэд тодорхой хугацаанд дээрх аймгуудад оршин сууж, хотын амьдралын хэв маягт дасан зохицсоныхоо дараа шилжих хөдөлгөөний 'эцсийн цэг' болох Улаанбаатар хотыг зорьдог болохыг илтгэж байна.

Хүснэгт 4: Хүн амын цэвэр шилжилтийн коэффициент, 1990-2010 он

Аймаг, хот	1990	1995	2000	2010
Архангай	-714	-1185	-3123	-3773
Баян-Өлгий	-249	-55	-338	-595
Баянхонгор	-598	-770	-2330	-2585
Булган	-195	-520	-1490	-1038
Говь-Алтай	-877	-1091	-3128	-1687
Дорноговь	-288	-351	826	348
Дорнод	-433	-705	-1652	-2755
Дундговь	-439	-708	-2143	-3676
Завхан	-70	-1291	-5013	-3667
Өвөрхангай	-345	-679	-2028	-5121
Өмнөговь	-116	-224	-174	8504
Сүхбаатар	33	-170	-979	-1551
Сэлэнгэ	-36	29	-345	-999
Төв	-11	-636	-2065	-318
Увс	592	-1206	-4724	-3881
Ховд	174	-104	-1483	-2631
Хөвсгөл	-172	-671	-2029	-3357
Хэнтий	69	-394	-2198	-1813
Дархан-Уул	245	734	1948	1209
Улаанбаатар	2619	6911	32678	40641
Орхон	1238	2414	2026	448
Говьсүмбэр	-	203	15	307

Эх сурвалж: Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, УСГ, УБ., 2003, 31 дэх тал
Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Үндсэн үр дүн, УСХ, УБ., 2011, 38 дахь тал

Ирээдүйд шилжихийг хүсэж буй иргэдийн 46.9-61.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод шилжин суурьших бодолтой байгаа¹⁴ гэсэн судалгааны мэдээлэлтэй дээрх баримт нь уялдаж байна. Түүнчлэн сүүлийн хоёр тооллогын

дүнгээс Улаанбаатар хотын уугуул иргэдийн 92.3 хувь нь шилжих хөдөлгөөнд оролцоогүй буюу өөр бүсэд шилжин суурьших сонирхол бага байгаа нь харагдлаа.

Ийнхүү 1990-ээд оноос Монгол Улсын хүн амын дунд дотоод шилжих хөдөлгөөний түвшин нэмэгдэж, урсгал нь үндсэндээ нийслэл Улаанбаатар хот руу чиглэж байгааг дараах шалтгаанаар тайлбарлаж болно.

¹³ Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Шилжих хөдөлгөөн, суурьшил сэдэвчилсэн судалгаа, Үндэсний статистикийн хороо, УБ., 2011, 18-20 дахь тал

¹⁴ Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлан, НХХЯ, ХАССТ, НҮБХАС, УБ., 2009, 98 дахь тал

Үүнд:

Нэг. Монгол Улс түүхийн бараг бүх үед хот, хөдөөгийн ялгаатай байдалд холбогдох асуудлаар нийгмийн баримжаатай төрийн бодлого хэрэгжүүлэх оролдлого хийсэн гэж үзэж болно. 1990-ээд оноос өмнө хот, хөдөөгийн ялгаатай байдлыг багасгах үзэл баримтлал дараах агуулгатай байв¹⁵. Үүнд:

- Хөдөөгийн хөгжлийг дэмжихэд хөрөнгө хүчийг харамгүй зарцуулах
- Хөдөөд хүн амыг суурьшуулах
- Хот руу шилжих хөдөлгөөнийг хязгаарлах
- Хот, хөдөөгийн харилцааг хөндлөнгөөс захиргаадан зохицуулах
- Иргэний оролцоог захиргааны аргаар журамлах зэрэг болно.

Тухайлбал, 1940-өөд оны социалист бүтээн байгуулалтын эхний жилүүдэд нийслэл Улаанбаатар хотод аж үйлдвэр, барилга, эрчим хүч зэрэг гол салбарууд төвлөрөх байдал бий болоход эдийн засгийн болон хүн амын төвлөрлийг

сааруулах анхны оролдлого нь бүх аймгуудад хүнсний үйлдвэр байгуулсан явдал байв. Түүнчлэн өмнө паспортын чанга дэглэмээр дамжуулан шилжих хөдөлгөөнийг хянах оролдлого хийж байсан талаар дурьдсан билээ.

Харин 1990-ээд оноос эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт нь хот суурин газарт нөөц, бололцоо төвлөрөх байдлыг өргөтгөснөөр хот, нэн ялангуяа Улаанбаатар хотын татах хүчин зүйлийн нөлөөгөөр шилжих хөдөлгөөн ихээхэн эрчимжив. Тодруулбал, хөдөөд малаас бусад барааны үнэ харьцангуй өндөр, ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн, эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээ хоцронгуй зэрэг нь шилжих хөдөлгөөний урсгалыг хөдөөнөөс төв суурин газар, нийслэл рүү хандуулах хүчин зүйл болсоор байна¹⁶.

Хүснэгт 5-д 2013 оны 5-р сарын 1-ний байдлаар зарим гол нэрийн бүтээгдэхүүний үнэ ямар байгааг Улаанбаатар хот болон бүсийн төлөөлөл болгон бүс бүрээс нэг нэг аймгийг авч харьцуулан харууллаа.

Хүснэгт 5: Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, зарим аймгаар, 2013 оны 5 сарын 1- ний байдлаар

Аймаг, хот	Үхрийн мах (ястай)	Хонины мах (ястай)	Цагаан будаа	1-р зэргийн гурил	Сүү (савлаагүй)	Шатахуун АИ 92
Улаанбаатар	8871	8088	1600	711	1300	1670
Баянхонгор	8000	7500	1600	900	2500	1850
Ховд	7500	7500	1700	900	2000	2050
Хэнтий	7500	7000	1600	900	1500	1850
Дундговь	8500	7500	1650	950	1600	1820

Эх сурвалж: ҮСХ-ноос гаргасан үнийн мэдээ, http://web.nso.mn/downloads/week_price/UNE130501.pdf

Монгол хүний хүнсний нэн чухал хэрэгцээ болох махны үнэ Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас 4.4-15.5 өндөр байна. Харин бусад бараа бүтээгдэхүүний үнэ Улаанбаатар хотод харьцангуй хямд байна. Ялангуяа, литрийн савлаагүй сүүний үнэ Ховд, Баянхонгор зэрэг аймгуудаас 700-1200 төгрөгөөр доогуур байгаа нь сонирхол татсан үзүүлэлт байна.

Бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тодорхойлогч хамгийн гол нэрийн бүтээгдэхүүн болох шатахууны үнэ 8.9-22.7 хувиар өндөр байгаа нь бага зөрүү биш юм. Үүний улмаас өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээ аймгууд дотооддоо тэр болгон хангах боломжгүй, дийлэнх импортын бүтээгдэхүүн Улаанбаатараар дамжин эцсийн хэрэглэгчдэд очиж

15 Г. Чулуунбаатар, XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэнийн өөрчлөлт, УБ., 2008, 145 дахь тал

16 Г. Чулуунбаатар, XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэнийн өөрчлөлт, УБ., 2008, 140 дэх тал


буй нөхцөлд хүнс, ахуйн болон бусад хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өртгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг болж байна.

Өнөөдрийн байдлаар МУ-ын нийт аж ахуйн нэгж байгууллагын 68.6 хувь; барилга угсралтын ажлын 67.0 хувь; их, дээд сургуулийн 88.5 хувь нь тус тус Улаанбаатар хотод төвлөрч байна. Түүнчлэн улсын хэмжээний нийт

борлуулалтын 4/5-өөс илүү нь Улаанбаатар хотод хийгдэж, үндэсний баялгийн 3/5-аас илүү нь бүтээгддэг¹⁷ байна.

Үүнтэй холбоотойгоор нийслэл нь орчин ахуй, боломж, чадавхийн хувьд бусад аймгуудаас харьцангуй илүү болж, өөрөөр хэлбэл энд татах хүчин зүйлүүд илүүтэй төвлөрч байгаа нь харагдаж байна. Жишээ болгон нэг хүнд ногдох ДНБ-ыг авч үзэхэд дараах дүр зураг тодорно.

Зураг 3: Нэг хүнд ногдох ДНБ, бүсээр (мян. төг), 2011 он



Эх сурвалж: Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд, НХХЯ, УБ., 2012, 48-110 дахь тал

Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ баруун бүсийн аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ээс 4 дахин, зүүн болон хангайн бүсийн нэг хүнд ногдох ДНБ-ээс 3 дахин, төвийн бүсийн нэг хүнд ногдох ДНБ-ээс 2 дахин тус

тус өндөр түвшин байна. Ийнхүү нэг хүнд ногдох орлогын түвшин өндөр байгаа явдал нь өрх, иргэдийн худалдан авах чадвар өндөр, ядуурлын түвшин доогуур байх явдлыг нөхцөлдүүлж байна.

Хүснэгт 6: Ядуурлын түвшин, байршлаар Монгол улс, 2002-2010 он

Байршил	2002-2003	2006-2007	2009	2010
Улсын дундаж	36.1	35.2	38.7	39.2
Улаанбаатар	27.3	21.9	26.7	29.8
Аймгийн төв	33.9	34.9	37.0	36.2
Сумын төв	44.5	42.0	42.6	38.8
Хөдөө	42.7	49.7	53.2	54.2

Эх сурвалж: Монголын хүний хөгжлийн илтгэл 2011. Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин, хүний хөгжил, УБ., 2011, 72 дахь тал

Ядуурал улсын дунджаар 39.2 хувьтай байхад Улаанбаатарт аймгийн төв, сумын төв, хөдөө зэрэг байршлын бүх ангиллаас доогуур буюу 29.8 хувьтай байна. Цаашилбал, дэд бүтцийн хангамж, боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн үйлчилгээний хүртээмж, нийгэм, эдийн

засаг, санхүү, байгаль орчны байдлыг харуулсан цогц үзүүлэлт болох орон нутгийн хөгжлийн индекс Улаанбаатар бүсэд хамгийн өндөр байна.

¹⁷ Улаанбаатар хот нэг өдөр 2011 он, Нийслэлийн статистикийн газар, УБ., 2012, 9-15 дахь тал

Хоёр. 1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулиар *Монгол Улсын иргэн бүр улс орныхоо нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, амьдрах газраа сонгох* эрхийг баталгаажуулж өгсөн явдал нь шилжих хөдөлгөөн нэмэгдэхэд нөлөөлсөн нэг шалтгаан мөн. Энэ талаар “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар”, “Дотоод шилжих хөдөлгөөн ба түүний нийгмийн эрүүл мэндийн үр дагавар” судалгааны тайлангууд, 2005 онд болсон Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалтын илтгэлүүдэд тэмдэглэсэн байна.

Иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа өөрөө сонгох эрх нь хүний хувийн эрх чөлөөний нэг төрөл бөгөөд хүн бүрт өөрийн амьдрал ахуйгаа хөтлөн явуулах, амьдрах орчноо бүрдүүлэх, оюун санаагаа хөгжүүлэх, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход чухал ач холбогдолтой эрх билээ.

Гурав. Социализмын үед амьжиргаа, аж төрөх ёс хэмээх ойлголтууд нь үзэл суртлын агуулгатай байж, ард түмний амьдрал дээшилж байх нь зөвхөн социализмын үед л байдаг үзэгдэл гэсэн үзэл суртлыг номлож байсан¹⁸ билээ. Тухайн үед ард нийтээрээ л өөрсдийн хөдөлмөрийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэлгээрээ тухайн үеийн мөнгөний ханш, бараа таваар, үйлчилгээний үнэ тарифын болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцооны нөхцөлд амьдрал ахуйгаа залгуулж байв.

1990 оноос эхэлсэн ардчилал, зах зээлийн тогтолцоо нь хувь хүн, өрх гэрт өөрөө өөрийнхөө төлөө хөдөлмөрлөх шаардлага, бололцоог бий болгосон юм. Зах зээлийн тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс амьжиргаагаа хэвийн авч явахад төрөл бүрийн арга замуудыг эрэлхийлэх болсон бөгөөд эдгээрийг бүлэглэн авч үзвэл:

1. Орон нутагтаа суурьшин орлого олох боломжийг хайж, арилжаа наймаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид;

2. Амьдрах орчноо сольж, хөдөөгөөс хот суурин газарт шилжигчид;

3. Гадаад улс оронд албан болон албан бус шугамаар явж, ажил хөдөлмөр эрхлэгчид;

4. Нийгмийн тусламж, дэмжлэг, байгалийн баялагт дулдуйдан хэт бэлэнчлэх сэтгэлгээгээр амьжиргаагаа дээшлүүлэхийг хүсэгчид; зэрэг ангилал¹⁹ гаргаж болохоор байна.

Үүнээс үзвэл ажил эрхлэх, амьдрал ахуйгаа өөд татах нэг эрэлхийлэл нь шилжих хөдөлгөөн, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн болж байна. Үүнийг үндэсний хэмжээнд хийгдсэн шилжих хөдөлгөөний асуудлаарх түүвэр судалгаанууд батлан харуулав (Хүснэгт 7).

Аймаг, хотод бүрмөсөн шилжин ирсний тодорхойлолт ХААТР-23, аймаг, хотоос бүрмөсөн шилжин явсаны тодорхойлолт ХААТР-24 маягтуудын үндсэн дээр цуглуулсан шилжих хөдөлгөөний бүртгэлийн мэдээлэл нь *иргэд ямар шалтгааны улмаас шилжихэд хүрэв?* гэдэгт бүрэн дүүрэн хариулт өгч чаддаггүй учраас тоон болон чанарын судалгааны мэдээлэлд тулгуурлан шилжилтийн шалтгааныг тодруулж байгааг энд тэмдэглэе.

Хүмүүс ганцаараа буюу гэр бүлээрээ төрсөн, өссөн нутагт орноо орхин шилжих хөдөлгөөнд оролцох шалтгаан нь ажил хөдөлмөр эрхлэх, зах зээл бараадан үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг хувь хүн, өрхийн амьдрал ахуйтай холбоотой шалтгаанууд байна. Өөрөөр хэлбэл, байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн улмаас малгүй болсон, ажлын байрны хомсдол, ур чадварын дутагдал, эдийн засгийн хямрал зэргээс хамааран ажилгүй болсон иргэд амьжиргааны эх үүсвэр хайн хот суурин газрыг барааддаг байна.

18 Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн өөрчлөлт. Ц. Уртнасан (Ред.), ШУА-ФСЭХ, УБ., 2001, 18 дахь тал

19 Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн өөрчлөлт, Ц. Уртнасан (Ред.), Шинжлэх ухааны академи, Философи, Социологи эрхийн хүрээлэн, УБ., 2001, 18 дахь тал

Өнөөдрийн амьдрал нь боломжийн байгаа боловч аж амьдралаа илүү дээшлүүлэх гэсэн хүсэл эрмэлзлэлийн үндсэн дээр мөн л шилжих хөдөлгөөнд оролцож байна. Нэг үгээр хэлбэл

амьжиргаагаа дээшлүүлэхэд хувь хүн, өрх гэр бүл онцгой үүрэг, ач холбогдолтой болохыг ард түмэн бүрэн ухамсарлаж²⁰, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй амьжиргааны нэг арга зам нь шилжих хөдөлгөөн болж байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотод шилжин суурьших болсон гол шалтгаан

Шилжих хөдөлгөөний талаарх Үндэсний хэмжээний зарим судалгаа	Улаанбаатар хотод шилжин суурьших болсон гол 5 шалтгаан (хариултын давтамж буурах эрэмбээр)
Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000, 2001	Ажил эрхлэх Зах зээлд ойртох Амьдралын нөхцлөө сайжруулах Хүүхдүүдийнхээ ирээдүйг бодож Төрөл саднаа бараадах
Дотоод шилжих хөдөлгөөн ба түүний нийгмийн эрүүл мэндийн үр дагавар, 2003	Амьжиргаагаа сайжруулах Төрөл саднаа бараадах Хүүхдийнхээ ирээдүйг бодох Зах зээлд ойртох Ажил эрхлэх
Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, 2004	Ажил эрхлэх Амьжиргаагаа дээшлүүлэх Суралцах, боловсрол эзэмших Зах зээлд ойртох Хамаатан садантайгаа ойртох
Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгаа, 2007	Ажил эрхлэх Хот суурин газар бараадах Амьжиргаагаа дээшлүүлэх Зах зээлд ойртох Суралцах, боловсрол эзэмших
Шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн байдал, тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ, 2007	Ажил эрхлэх Хот бараадан, соёл олон нийтийн үйлчилгээнд ойртох Хүүхдээ чанартай, сайн боловсрол эзэмшүүлэх Хамаатан садан, үр хүүхдээ түшиж амьдрах Амьжиргааны эх үүсвэргүй, малгүй болсон
Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар, 2009	Хот газар бараадах Ажилгүй болсон Хамаатан, хүүхдээ түших, бараадах Хүүхдээ сайн ЕБС-д сургах/Хүүхэд оюутан болсон Ган зудын улмаас/амьжиргааны эх үүсвэргүй болсон

20 Монголын нийгмийн өөрчлөлт, ШУА-ФСЭХ, Б. Дааш-Ёндон (Ред), УБ., 2008, 194-195 дахь тал

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Д.Базаргүр, (2005). *Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэл, нийгэм эдийн засгийн хөгжлийн стратеги*, УБ
- Ц.Болормаа, А. Солонго, Б. Мөнхжаргал, (2005). *Хүн амын бодлого сурах бичиг*, ХАССТ, НҮБХАС, УБ
- Х.Гүндсамбуу, (2002). *Монголын нийгмийн давхраажил: Хөгжил, хандлага, Удирдлагын академи*, УБ
- ДЭМБ, ЭМЯ, ЭТУГ, (2003). *Дотоод шилжих хөдөлгөөн ба түүний нийгмийн эрүүл мэндийн үр дагавар*, УБ
- СЭЗЯ, НҮБХХ, (2004). *Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд судалгааны тайлан*, УБ
- Ж.Дүгэрсүрэн, (1963). *Улаанбаатар хот 1921-1940*, УБ
- Б.Даш-Ёндон (Ред), (2008). *Монголын нийгмийн өөрчлөлт*, ШУА-ФСЭХ, УБ
- Ч.Жамбал, (1984). *Орчин цагийн Улаанбаатар*, УБ
- Ж.Заанхүү, Т. Алтанцэцэг, (1999). *Монголын түүхийн лекцүүд*, Цагдаагийн дээд сургууль, УБ
- С.Идшинноров, (1994). *Улаанбаатар хотын түүхийн хураангуй*, УБ
- Кэролин Хамфри, Дэвид Снит, (2006). *Нүүдэллэхүй ёсон эцэслэх үү?: Өвөр Азийн нийгэм, төр, хүрээлэх орчин* (Орч. Ц. Очирбал), УБ
- МХАХН, ХАССТ (2012). *Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөлөл*, МУ-ын Засгийн газар, НҮБХАС, *Монголын хүн амын сэтгүүл*, Дугаар 6-13
- Д.Мягмар, (1975). *БНМАУ-ын хүн амын хөдөлмөр эрхлэлт, шилжих хөдөлгөөний асуудал*, УБ
- Т.Намжим, (2004). *Монгол Улсын эдийн засаг: Эрт, эдүгээ, чинагш*, Боть 1-3, УБ
- Б.Нарантулга, Ч. Баатар, (2010). *Орон нутгийн хөгжил: Бодлогын суурь үзэл баримтлал*, НҮБХС, УБ
- НХХЯ, ФСЭХ, НҮБХАС, (2010). *Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал*, Улаанбаатар их сургууль, УБ
- НХХЯ, ХАССТ, НҮБХАС, (2009). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлан*, УБ
- НХХЯ, ХАССТ, НҮБХАС, (2001). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000*, УБ
- НСГ, (2012). *Улаанбаатар хот нэг өдөр 2011 он*, Нийслэлийн статистикийн газар, УБ
- НҮБХАС, (2005). *Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт: Хэлсэн үг, илтгэл, илгээлт, зөвлөмж*, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хүн амын асуудлаарх Азийн парламентчдын форум, УБ
- НХХЯ, ХАССТ, НҮБХХ, (2004). *Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгааны тайлан*, УБ
- НХХЯ, (2011, 2012). *Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд*, УБ
- Нийгмийн хөгжлийн төв ТББ, СЯ, НҮБХХ, (2005). *Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл судалгааны тайлан*, УБ
- Ц.Уртнасан (Ред), (2001). *Нийгмийн шинэчлэл: Амьдралын хэв маягийн*

- өөрчлөлт, Шинжлэх ухааны академи, Философи, Социологи эрхийн хүрээлэн, УБ
- ҮСХ, (2002). *Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа*, УБ
- ҮСГ, (2003). *Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд*, УБ
- ҮСГ, АХБ, ДБ, (2006). *Монгол Улс: Оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь*, УБ
- ҮСГ, НҮБХАС, (2007). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгааны тайлан*, УБ
- ҮСХ, (2011). *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Үндсэн үр дүн, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Шилжих хөдөлгөөн, суурьшил сэдэвчилсэн судалгаа*, УБ
- ҮСХ, ДБ, (2009). *Монгол Улс дахь ядуурлын дүр төрх: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүн*, УБ
- ҮСХ, (2012). *Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2011*, УБ
- О.Сүхбаатар, (1975). *БНМАУ-ын хүн амын шилжих хөдөлгөөн*, УБ
- Г.Чулуунбаатар, (2008). *XX, XXI зууны зааг үеийн Монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт*, ШУА, ФСЭХ, УБ
- ЭМШУИС, НҮБХАС, Япон улсын Засгийн газар, (2007). *Шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн байдал, тусламж үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ судалгааны тайлан*, УБ